

ҮБХИС-ийн захирлын 2020 оны 5 дугаар сарын 21-ний өдрийн А/81 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан

МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ БАТЛАН ХАМГААЛАХЫН ИХ СУРГУУЛИЙН
БАКАЛАВРЫН БОЛОН МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛЫН ХӨТӨЛБӨРИЙН
ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Бакалаврын хөтөлбөр:

ҮБХИС-ийн бакалаврын хөтөлбөрүүд нь иргэний болон цэрэг, батлан хамгаалахын гэсэн үндсэн хоёр чиглэлийн сургалтыг хамааруулна.

Иргэний чиглэлээр: - Аюулгүй байдлын дээд сургуульд байгаль, нийгмийн ухаанд суурилсан Эдийн засаг, Төрийн удирдлага, Авто инженер, Менежмент, Системийн аюулгүй байдал зэрэг үндсэн хөтөлбөрүүд, Цэргийн хөгжмийн коллеж хөгжмийн урлаг хөтөлбөрөөр тус тус боловсролын бакалаврын зэрэг олгоно. Иргэний чиглэлийн хөтөлбөрүүдэд эмэгтэй элсэгчдийн эзлэх харьцаа 30 хүртэл хувь байж болно. Боловсролын бакалаврын зэрэг эзэмшигч эрэгтэй оюутнууд нь “Цэргийн албаны тухай” Монгол Улсын хуулийн дагуу суралцах хугацаандаа цэргийн мэргэжлийн сургалтад хамрагдаж хугацаат цэргийн алба хаасанд тооцогдож цэргийн нэгдүгээр зэргийн бэлтгэл үүрэгтнээр бүртгэгдэнэ. Цэргийн мэргэжлийн сургалтад хамрагдах оюутан нь бие бялдар, эрүүл мэндийн хувьд хугацаат цэргийн албанд тавигдах шаардлагыг хангасан байна.

ОХУ, БНХАУ, ХБНГУ, ТУРК УЛС, БНЭУ, ЯПОН УЛС, БНСУ зэрэг арав гаруй орнуудтай байгуулсан гэрээний дагуу БХЯ, ЗХЖШ-аас ирүүлсэн захиалгыг үндэслэн “Инженерийн бэлтгэл” ангид суралцуулах зорилгоор элсэгчдийн хяналтын тоог нэмэгдүүлэх арга хэмжээг тухайн нөхцөл байдалд нийцүүлэн захирлын тушаалаар шийдвэрлэнэ.

Цэрэг, батлан хамгаалахын чиглэлээр: - Цэргийн нэгдсэн дээд сургуульд Ерөнхий цэргийн команд, Артиллери, Цэргийн инженер, Цэргийн зэвсэглэл, Зенитийн пуужин – автоматжуулалт, Зенитийн артиллери – Электроник, Цэргийн холбооны инженер, Радио техникийн команд, Цэргийн хими, хамгаалалт зэрэг хөтөлбөрүүдэд Зэвсэгт хүчин, төрийн цэргийн байгууллагын офицерийн албанд ажиллах хүсэл, эрмэлзэлтэй, ҮБХИС-ийн Аюулгүй байдлын дээд сургуульд 2 жилийн хугацаанд байгаль, нийгэм, хүмүүнлэгийн ухааны ерөнхий суурь, мэргэжлийн суурь хичээлийн бүлэг хөтөлбөрүүдийг бүрэн судалсан, сурлага, төлөвшил, бие бялдрын тусгай шаардлага, гадаад хэлний зохих бэлтгэл хангасан оюутныг сонгон шалгаруулалтаар Цэргийн нэгдсэн дээд сургуульд шилжүүлэн суралцуулж төрийн цэргийн байгууллагуудын мэргэжил, хяналтын тоо, захиалгын дагуу цэргийн ухааны бакалаврын зэрэг олгож төгсгөнө.

1.2. Мэргэжлийн боловсролын хөтөлбөр:

а. Цэргийн хөгжмийн коллеж /ЦХК/ нь хөгжимдөх урлаг /мэргэжлийн боловсрол/-ийн хөтөлбөрт Ерөнхий боловсролын сургуулийн 9 дүгээр анги төгссөн хөгжмийн авьяастай сурагчдыг элсүүлэн 4 жил цэргийн үлээвэр хөгжмийн сурагчаар суралцуулж, дипломын боловсрол бүхий хөгжимчин ахлагчаар төгсгөнө.

б. Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв /БХМСҮТ/ нь цэргийн зэвсэглэл, техник, тусгай тоноглол, төхөөрөмжийн чиглэлээр мэргэжлийн

боловсрол олгох хөтөлбөрт **22** хүртэлх насны иргэдийг элсүүлэн 1 жилийн хугацаанд суралцуулж цэргийн мэргэжил эзэмшүүлэн Зэвсэгт хүчний ахлагчийн албанд шилжүүлнэ.

1.3. ҮБХИС нь БСШУС-ын сайдын 2020 оны А/195 дугаар тушаалаар батлагдсан “Их дээд сургууль, сургуулийн хичээл, сургалтын үйл ажиллагаанд зарим зохицуулалт хийх тухай” тушаал, мөн сайдын баталсан дээд боловсролын сургалтын байгууллагад “Оюутан элсүүлэх журам”, “Үндэсний батлан хамгаалахын их сургуулийн дүрэм”, “ҮБХИС-д боловсролын бакалаврын зэрэг олгох сургалтын журам” болон энэхүү журмыг удирдлага болгон элсэлтийг цахим хэлбэрээр зохион байгуулна.

1.4. ҮБХИС-д элсэхээр бүртгүүлэгч, элсэгч болон элсэлтийн комиссын үйл ажиллагааг энэ журмаар зохицуулна.

1.5. ҮБХИС-ийн бакалаврын болон мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэхээр хүсэлт гаргасан иргэнийг “бүртгүүлэгч”, зохих болзол хангаж элсэлтийн хяналтын тоонд багтсан бүртгүүлэгчийг “элсэгч”, Онлайн бүртгэлийн системийг “бүртгэлийн систем”, элсэлтийг зохион байгуулахаар томилогдсон төв болон бакалаврын, мэргэжлийн боловсролын хөтөлбөрийн комиссыг “элсэлтийн төв болон салбар комисс”, элсэлтийн үйл ажиллагаанд оролцох ажилтныг “комиссын гишүүн” гэнэ.

1.6. Энэхүү журмыг ҮБХИС-ийн <http://mndu.gov.mn/elselt/>, <http://mndu.gov.mn> болон Боловсролын үнэлгээний төвийн <http://www.eec.mn> хаяг, цахим болон төвийн хэвлэл, мэдээллийн хэрэгсэлд байршуулан, бүртгүүлэхийг хүсэгчдэд танилцах нөхцөл боломжийг бүрдүүлнэ.

1.7. Журмын хэрэгжилтэд төрийн захиргааны төв болон бусад байгууллага, олон нийт, эцэг, эхийн төлөөлөл, ҮБХИС-ийн удирдлагын зүгээс хөндлөнгийн хяналт тавих нөхцлийг бүрдүүлсэн байна.

1.8. Улаанбаатар хотод явагдах элсэлтийн үйл ажиллагааг БСШУСЯ-аас албан ёсоор тогтоосон өдрөөс эхлэн ажлын 10 өдөрт багтаан зохион байгуулна.

1.9. Бакалаврын хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Цэргийн нэгдсэн дээд сургууль, Аюулгүй байдлын дээд сургууль, Цэргийн хөгжмийн коллеж, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрийг хэрэгжүүлэгч нь Цэргийн хөгжмийн коллеж, Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв байна.

Хоёр. Бүртгүүлэгчдэд тавих шаардлага

2.1. Элсэхээр бүртгүүлэгч нь өөрийн хүсэл сонирхол, итгэл үнэмшлээрээ сонголтоо хийсэн, бие бялдрын болон гадаад хэлний шаардлагыг хангасан, ёс суртахууны зөв хүмүүжил, төлөвшилтэй, суурь өвчингүй, нийгмийн хэв журам, хууль, дүрмийг хүндэтгэн сахиж биелүүлэх талаар өөрийн төлөвшил хандлагыг итгэл үнэмшил болгон эрхэмлэдэг, бүрэн дунд, түүнээс дээш боловсролтой Монгол Улсын иргэн байна.

2.2. Орон нутгаас суралцагч элсүүлэх хуваарьт зөвхөн тухайн аймагт оршин суугаа иргэд, Улаанбаатар хотоос элсүүлэх хуваарьт нийслэл хотод оршин суудаг харьяаллын бүртгэлтэй “Элсэлтийн ерөнхий шалгалт” /ЭЭШ/ өгсөн иргэд бүртгүүлнэ.

2.3. Орон нутагт элсэлтийн ерөнхий шалгалт өгсөн бүртгүүлэгч нь Улаанбаатар хотын элсэлтэд хамрагдах тохиолдолд Боловсролын үнэлгээний төвд бүртгүүлсэн байна

2.4. Улаанбаатар хот болон хөдөө орон нутагт элсэгчдийг цахим хэлбэрээр элсүүлнэ.

2.5. Бүртгүүлэгч нь сонгосон бүлэг хөтөлбөрт хамаарах элсэлтийн шалгалтын хичээлээр 2018, 2019, 2020 онд ЭЕШ өгсөн аль нэг батламжаар элсэн суралцах эрх эдлэнэ. /Бүртгүүлэгч нь зөвхөн хүчин төгөлдөр нэг батламжаар бүртгүүлэх эрхтэй байна./

2.6. Цахим бүртгэлд амжилттай бүртгэгдсэн, элсэлтийн ерөнхий шалгалтын оноогоороо тухайн сонгосон бүлэг хөтөлбөрийн шаардлагыг хангасан элсэгч сургалтын төлбөрийн 50 хувийг төлж суралцах эрхээ баталгаажуулна.

2.7. Бүртгүүлэгч нь ҮБХИС-д бүртгүүлэхээс өмнө элсэлтийн ерөнхий шалгалтын шалгуулагчийн буланд нэвтэрч, өөрийн хувийн мэдээлэл болон дүнтэй танилцаж, зөрчилтэй асуудал байвал урьдчилан шийдвэрлүүлсэн байна.

2.8. Хөтөлбөрийн онцлогоос хамаарч бүртгүүлэгч нь энэ журмын 4.3-д заасан ур чадварын шалгалт өгнө.

2.9. Бакалаврын болон мэргэжлийн боловсролын хөтөлбөрүүдэд элсэгч нь элсэлтийн шалгалтын хичээл тус бүрээр дараах босго оноог хангасан байна

Бүлэг	Хөтөлбөр	Элсэлтийн шалгалтын хичээл, Босго оноо	
		I-хичээл	II-хичээл
I	Математик суурьтай хөтөлбөр - I	Математик 480	Нийгмийн тухай мэдлэг 480
II	Математик суурьтай хөтөлбөр - II	Математик 480	Физик 480
III	Физик суурьтай хөтөлбөр	Физик 480	Математик 480
IV	Нийгмийн тухай мэдлэг суурьтай хөтөлбөр	Нийгмийн тухай мэдлэг 480	Математик 480
V	Хими суурьтай хөтөлбөр	Хими 480	Математик 480
VI	Монгол хэл суурьтай хөтөлбөр /Хөгжмийн урлаг/	Монгол хэл 480	Нийгмийн тухай мэдлэг 480
VII	Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр	Математик 480	Физик 480

2.10. Сургалт, эрдэм шинжилгээ, спорт, зохион бүтээх инженерчлэлийн чиглэлээр олон улсын хэмжээний олимпиад, уралдаан тэмцээнд онцгой амжилт гаргасан элсэхийг хүсэгчдэд тус сургуульд элсэн суралцах босго оноог хангасан тохиолдолд “Ур чадварын шалгалт”-аас чөлөөлнө.

2.11. Босго /хэмжээст/ оноо нь хоёр хичээл тус бүрт **700-аас** дээш оноотой элсэгчдийг бакалаврын хөтөлбөрийн сургалтын төлбөрөөс **100%** чөлөөлөн элсүүлэн суралцуулна.

2.12. ЗХЖШ, бусад төрийн цэргийн байгууллагуудын **30** хүртэлх насны ахлагч өөрийн харьяа байгууллагын зөвшөөрлөөр бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхдээ ЭЕШ-ын оноогоороо бусад элсэгчидтэй ижил түвшинд өрсөлдөнө. ЭЕШ-ын шаардлагыг хангаагүй тохиолдолд элсэн суралцах боломжгүй. Элсэн суралцах болзол хангасан нөхцөлд цэргийн жинхэнэ албанаас бэлтгэлээр халагдаж оюутны нэгэн адил эрх, үүрэг хүлээнэ.

2.13. Хөгжмийн урлаг хөтөлбөрт ур чадварын шаардлага хангасан, хөгжимчний мэргэжлийн дипломтой, “ЭЕШ”-ын хүчин төгөлдөр батламжтай **22** хүртэлх насны хөгжимчин ахлагч болон иргэдийг элсүүлэн суралцуулна.

2.14. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт **22** хүртэлх насны иргэдийг /эрэгтэй/ элсүүлэн цэргийн тусгай мэргэжил эзэмшүүлнэ. /Цэргийн албаны тухай Монгол Улсын хуулийн 9.5 заалтын дагуу энэхүү хөтөлбөрт суралцагчдын ахуй хангалт, дүрэмт хувцсыг төр хариуцна /.

2.15. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгчид 165 см-ээс дээш өндөртэй, 60 кг-аас багагүй жинтэй, биед сорви, шивээсгүй ямар нэг гаж зуршилгүй байх шаардлага хангасан байвал зохино.

2.16. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэлтийн шаардлага хангасан цэргийн хугацаат болон гэрээт алба хаагчдыг ЗХЖШ-ын даргын цэргийн албанаас халсан тухай тушаал, анги, байгууллагын албан бичиг, гэмт хэрэгт холбогдож байгаагүйг нотлох цагдаагийн тодорхойлолт зэргийг үндэслэн элсүүлэн суралцуулж болно.

2.17. Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт эмэгтэй иргэдийг элсүүлэн суралцуулахгүй.

2.18. Гадаад улсад бүрэн дунд боловсрол эзэмшсэн Монгол Улсын иргэнийг Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын элсэлтийн ерөнхий шалгалттай дүйцэх шалгалт өгсөн тухай тодорхойлолтыг үндэслэн элсүүлнэ.

2.19. Монгол Улсын засгийн газрын 2017 оны 144 дүгээр тогтоолоор батлагдсан “Иргэнийг цэргийн жинхэнэ албанд эрүүл мэндээр тэнцүүлэх болон цэргийн алба хаагчийн эрүүл мэндийн байдлыг тодорхойлох журам”-ын дагуу **биед сорви, шивээсгүй** нөхцөлд цэргийн сургуульд сонсогчоор элсүүлэн суралцуулах боломжтой. Иймээс элсэхээр бүртгүүлэгчид нь үзлэг хийх үед шивээс, сорви илэрсэн тохиолдолд элсэн суралцах боломжгүй болно.

Гурав. Элсэлтийн бүртгэл

3.1. Элсэлтийн бүртгэлийг орон нутагт Монголын их, дээд сургуулиудын консорциум тусгай журам, хуваарийн дагуу, Улаанбаатар хотод цахим хэлбэрээр <http://mndu.gov.mn/elselt> хаягаар явуулна.

3.2. Улаанбаатар хотод элсэлтийн цахим бүртгэл **2020 он 6 дугаар сарын 15-ны өдрийн 08.00** цагт эхэлж, **7 дугаар сарын 6-ны өдрийн 23.00** цагт дуусгавар болж хаагдана.

3.3. Бүртгүүлэгч системд ЭЕШ-ын бүртгэлийн дугаар, нууц үгээ оруулснаар элсэх хүсэлтээ гаргана.

3.4. Системд амжилттай нэвтэрсэн үед системээс бүртгүүлэгчийн хувийн болон ЭЕШ-ын мэдээллийг дэлгэцэнд харуулах ба хүндрэлтэй асуудал үүссэн тохиолдолд элсэлтийн комисс болон Боловсролын үнэлгээний төвд хандаж шийдвэрлүүлнэ.

3.5. Хувийн мэдээллийг баталгаажуулсны дараа сонирхсон хөтөлбөрийнхөө талаарх дэлгэрэнгүй мэдээллийг авах боломжтой.

3.6 Системд хувийн мэдээлэл, ЭЕШ-ын бүртгэлийн дугаар, нууц үгээ буруу оруулснаас болж үүсэх асуудлыг элсэлтийн комисс хариуцахгүй болно.

Дөрөв. Элсэгчийг шалгаруулах

4.1. Босго оноог хангасан бүртгүүлэгчдээс сонгон шалгаруулалт хийхдээ хавсралтад заасан шалгалтуудын оноог 100 хувиар бодон нэмж хэмжээст оноог гарган онооны дарааллаар байр эзлүүлэн хуваарь сонгуулах журмыг баримтлана. Жишээ нь: Тухайн сонгосон хөтөлбөрийн хоёр шалгалтын оноог 100 хувийн харьцаагаар нэмнэ. Элсэгч нэгдүгээр хичээлд 480 оноо, хоёрдугаар хичээлд 480

оноо авсан гэж үзвэл таны нийлбэр оноо $x = 480 + 480 = 960$ оноо болно. Энэхүү оноо нь элсэгчийн ҮБХИС-д элсэхийг хүсэгчдээс шалгаруулалт хийх хэмжээст оноо болно.

4.2.* Мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт (БХМСҮТ, ЦХК) элсэгчдийг **2020 оны 7 дугаар сарын 27-нд** Цэргийн төв эмнэлгийн цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамруулна. (Тухайн үеийн нөхцөл байдлаас шалтгаалан эрүүл мэндийн үзлэгт хамруулах хугацаа өөрчлөгдөж болно)

4.3.* Дараах хөтөлбөрүүдэд ур чадварын нэмэлт шалгалт авна. Үүнд:

- Хөгжмийн урлаг хөтөлбөрт элсэгчдээс сонсгол болон хөгжимдөх ур чадварын шалгалт авч, эдгээр ур чадварыг 100% гэж тооцон 70%-иас дээш амжилт үзүүлбэл тэнцэх шалгуурыг хангасан гэж үзнэ.

- Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төвийн мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөр, Цэргийн хөгжмийн коллежийн Хөгжмийн урлаг болон үлээвэр хөгжмийн хөтөлбөрт элсэгчдээс ур чадварын шалгалтыг **2020 оны 7 дугаар сарын 29-ны өдрийн 09.00** цагт ҮБХИС дээр авна (шалгалт авах байр, танхимыг бүртгэлийн үед мэдэгдэнэ). Шалгалтын дүнг **7 дугаар сарын 29-ны өдрийн 18.00** цагт системд байршуулж нийтэд мэдээлнэ.

МЭРГЭЖЛИЙН БОЛОВСРОЛ ОЛГОХ ХӨТӨЛБӨРТ ЭЛСЭГЧДИЙН ӨГӨХ БИЕ БЯЛДРЫН ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙН НОРМАТИВ

№	Бие бялдарын чанарууд	Дасгалын төрөл	Аргачлал	Тэнцүүлэх үзүүлэлт
1.	Хүч	Дүүжинд суниах	Тоо	12-оос дээш
2.		Гэдэсний таталт	Тоо	56-аас дээш
3.	Тэсвэр	3000 метрт гүйх	мин	12.30-аас дотогш
4.	Хурд	100 метрт гүйх	сек	15.0-оос дотогш

- Тайлбар: Дээрх 4 үзүүлэлтийн 3 ба түүнээс дээш дасгалыг биелүүлсэн тохиолдолд тэнцэнэ. 100 метр, 3000 метрийн гүйлтийн аль нэг дасгалд заавал тэнцсэн байвал зохино.

4.4. Онооны дарааллаар хөтөлбөр бүрээр цуваагаар байр эзлүүлж, хяналтын тоонд багтсан элсэгчдийн нэрсийг мэдээлийн самбарт байршуулна.

4.5. Цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын үзлэгээр эрүүл мэндээр тэнцэхгүй нь тогтоогдсон, бие бялдрын бэлтгэлжилтийн шалгуур үзүүлэлтийг хангаагүй элсэгчдийг жагсаалтаас хасч, онооны дарааллаар дараагийн бүртгүүлэгчид сонголтыг шилжүүлнэ.

Тав. Элсэгчээр бүртгэх

5.1.* Бакалаврын хөтөлбөрт тэнцсэн элсэгчдэд **8 дугаар сарын 01-04-ний** өдрийн, мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт элсэгчдэд **7 дугаар сарын 30-ны өдрийн 08.00-17.00** цагт “ҮБХИС-д суралцах эрхийн бичиг” олгоно.

5.2. Заасан хугацаанд ирж, суралцах эрхийн бичгээ аваагүй бүртгүүлэгчийг суралцахаас татгалзсанд тооцож онооны дарааллаар дараагийн элсэгчид сонголтыг шилжүүлнэ.

5.3. Бүртгүүлэгч нь эрхийн бичиг авахдаа дараах материалыг бүрдүүлсэн байна. Үүнд:

- Иргэний үнэмлэх /ахлагчийн үнэмлэх/
- ЭЕШ-ын батламж
- Боловсрол эзэмшсэнийг гэрчлэх баримт бичиг
- Сурагчийн хувийн хэрэг
- БХЯ, ЗХЖШ-ын зөвшөөрөл, анги байгууллагын тодорхойлолт /зөвхөн ахлагч нарт хамаарна/

- 3x4 хэмжээний цээж зураг 4 хувь
 - Төгссөн сургуулийн тодорхойлолт
 - Системээс илгээсэн бүртгэлийн хуудас
 - Өөрийн суралцах бэлтгэл, авъяас чадвар, туршлага, хувийн зан чанар, хэрхэн суралцахаа илэрхийлсэн эссе бичлэг /ҮБХИС-ийн элсэлтийн цахим хуудсанд байршуулсан загварын дагуу/
 - ҮБХИС-д элсэн суралцахыг хүссэн өргөдөл зэрэг материалуудыг битүүмжлэл сайтай хавтсанд хийж бүрдүүлсэн байна.
- 5.4. Элсэгч нь “ҮБХИС-ийн дүрэм”-д заасан суралцагчдад тавигдах шаардлагын дагуу Аюулгүй байдлын сургуулийн захирал, Эрдэм шинжилгээ, сургалтын албатай “Суралцах гэрээ” байгуулна.

Зургаа. Бусад

6.1. Сургалтын нэг хөтөлбөрөөс нөгөө хөтөлбөрт шилжин суралцах асуудлыг зөвхөн нэгдүгээр дамжааны эхний хагас жилийн хөтөлбөрийг бүрэн хангасан тохиолдолд анги дэвших тушаал гарахаас өмнө шийдвэрлэх ба суралцах эрхийг бусдад шилжүүлэхийг хориглоно.

6.2.* Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв, Цэргийн хөгжмийн коллежийн мэргэжлийн боловсрол олгох хөтөлбөрт орон нутгаас тэнцсэн элсэгчид:

- 7 дугаар сарын 26-ний өдөр Улаанбаатар хотод хүрэлцэн ирж ҮБХИС-ийн элсэлтийн комисст бүртгүүлнэ.
- 7 дугаар сарын 27-ны өдөр Цэргийн төв эмнэлгийн цэргийн нарийн мэргэжлийн эмч нарын эрүүл мэндийн үзлэгт хамрагдана.
- 7 дугаар сарын 29-нд ур чадварын шалгалт өгнө.
- 8 дугаар сарын 01-ны өдрөөс 8 дугаар сарын 30-ны өдрийг хүртэлх хугацаанд цэргийн анхан шатны бэлтгэл сургалтад хамрагдаж, цэргийн тангараг өргөнө.

6.3. Элсэгчид сургалтын төлбөрөө бүрэн төлсөн тохиолдолд Их сургуулийн удирдлага мэдээллийн “Cloud university V2” системд бүртгүүлэх эрх нээгдэж ҮБХИС-ийн оюутны код, үнэмлэх авах боломж бүрдэнэ.

6.4. Суралцах эрх авсан боловч заасан хугацаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр системийн бүртгэлд бүртгэлээ баталгаажуулаагүй элсэгчийг суралцахаас татгалзсан гэж үзэн суралцах эрхийг хүчингүйд тооцно.

6.5. Элсэлтийн цахим хуудас нь тогтмол ажиллагаатай нээлттэй үйлчилж элсэлттэй холбоотой мэдээллээр бүртгүүлэгчдийг хангана.

6.6. Элсэгчдэд бүрэлдэхүүн сургуулиуд хөтөлбөрүүдээ танилцуулах, зөвлөгөө өгөх үйл ажиллагааг зохион байгуулна.

6.7. ҮБХИС-д суралцах нөхцлийг хангасан “Бакалаврын зэргийн диплом”-той элсэгчдийг суралцуулах асуудлыг “ҮБХИС-д боловсролын бакалаврын зэрэг олгох сургалтын журам”-ын 4.10.2 дах заалтыг үндэслэн хэрэгжүүлнэ.

*** - Энэ журмын 4.2, 4.3, 5.1, 6.2 дах хэсгүүдэд заагдсан хугацаа нь цаг үеийн байдал, улсын онцгой комиссийн шийдвэрээс шалтгаалан өөрчлөгдөж болно. Хугацаанд өөрчлөлт орсон тохиолдолд элсэлтийн шалгалтын комисс элсэхээр бүртгүүлэгчидэд тухай бүр мэдээллэнэ.**

БАКАЛАВРЫН БҮЛЭГ ХӨТӨЛБӨР, ҮНДСЭН ХӨТӨЛБӨР

Хүснэгт 1

Бүлэг хөтөлбөр	Хөтөлбөр
Математик суурьтай хөтөлбөр- I	Ерөнхий цэргийн команд
	Эдийн засаг

	Менежмент
Математик суурьтай хөтөлбөр- II	Авто инженер
	Цэргийн инженер
	Артиллери
	Цэргийн зэвсэглэл
	Системийн аюулгүй байдал
Физик суурьтай хөтөлбөр	Зенитийн пуужин - автоматжуулалт
	Зенитийн артиллери – Электроник
	Радио техникийн команд
	Цэргийн холбооны инженер
Нийгмийн тухай мэдлэг суурьтай хөтөлбөр	Төрийн удирдлага /энэхүү хөтөлбөрт элсэгчдэд 4 дүгээр улирлын дараагаар цэргийн мэргэжлийн хөтөлбөрт шилжин суралцах боломж олгохгүй, зөвхөн иргэний мэргэжлээрээ суралцан төгсөнө./
Монгол хэл суурьтай хөтөлбөр	Хөгжмийн урлаг
Хими суурьтай хөтөлбөр	Цэргийн хими, хамгаалалт
Мэргэжлийн боловсролын бүлэг хөтөлбөр	Буудагч, ЯЦБМ-ны механик жолооч, ЯЦБМ-ны наводчик оператор, Танкийн механик жолооч, Танкийн буудагч, Хуягт тээвэрлэгчийн механик жолооч, Артиллерийн бууны захирагч, наводчик, Цахилгаан холбоо, компьютер сүлжээний техникч, Радиотелеграфчин, РЛС-ын оператор, планшетчин, Зэвсгийн нярав, засварчин, Химичин зааварлагч, Инженерийн дугуйт машины механик жолооч, Онгоц нисдэг тэрэгний хөдөлгүүрийн механикч, ЗУ-23-2-ын бууны наводчик, Артиллерийн тагнуулчин, гал засварлагч, Автын хөдөлгүүрийн засварчин, Автотехникийн цахилгаанчин, Тагнуулчин /гал засварлагч/, Сапёрчин тэсэлгээчин, Үлээвэр хөгжимчин.

Харилцах утас, хаяг:

- Сургалтын хэлтэс: 453164, info@mndu.gov.mn
- Аюулгүй байдлын дээд сургууль: 454132, mes@mndu.gov.mn
- Цэргийн хөгжмийн коллеж: 480168, moc@mndu.gov.mn
- Батлан хамгаалахын мэргэжлийн сургалт-үйлдвэрлэлийн төв: 450416, nco@mndu.gov.mn
- ҮБХИС-ийн жижүүр: 480908
- Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16 дугаар хороо, Улаанхуаран www.mndu.gov.mn/

СУРГАЛТЫН ХЭЛТЭС